

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

Mongolian Re
ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН

2018



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах, санхүүгийн зах зээлийн тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадвар бүхий давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэхэд хамтран ажилладаг эрхэм харилцагчид, байгууллагууд та бүхэндээ Үндэсний давхар даатгал ХК-ийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж байна.

Манай компани нь Монгол Улсын анхны давхар даатгалын компанийн хувьд стратегийн ач холбогдол бүхий салбар болох хөдөө аж ахуйн салбарыг болзошгүй эрсдэлээс хамгаалах ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа билээ. 2015 оноос хойш малын индексжүүлсэн даатгал (МИД), 2016 оноос газар тариалангийн даатгалыг Монгол орон даяар амжилттай зохион байгуулж байна.

Тайлант онд бидний хувьд олон амжилтыг авчирсан, их ажил ундарсан, туршлага нэмэгдсэн түүхэн жил байлаа. МИД-д даатгуулсан малчин өрхийн тоо Монгол Улсын нийт малчин өрхийн 19.8 хувийг эзэлсэн нь зөвхөн манай компанийн хувьд ч бус уг даатгалын түүхэн

дэх хамрагдалтын хувь хэмжээний хамгийн оргил цэг боллоо. Мөн бид олон улсын даатгалын салбарын хөгжилтэй хөл нийлүүлэх хэрэгцээ шаардлага болон Монгол Улсын эдийн засгийн бодлого, Засгийн газрын нэр бүхий олон хөтөлбөрүүдтэй нийцүүлэн Үндэсний давхар даатгал ХК болж үйл ажиллагаагаа өргөжүүллээ. Үндэсний давхар даатгалын тогтолцоог бий болгож байгаа нь даатгалын хураамж хэлбэрээр гадагшаа гарч байгаа гадаад валютын урсгалын тодорхой хэсгийг дотооддоо авч үлдэн, даатгалын зах зээлийн эрсдэл даах түвшин сайжруулж буй хэрэг юм. Ингэснээр даатгалын компаниудын төлбөрийн чадварыг дэмжиж даатгалын зах зээлийн нөөц хөрөнгө нэмэгдсэнээр бусад салбарт үзүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бага зардлаар эрсдэлийг хамтран хариуцах тогтолцоог бүрдүүлээд зогсохгүй улс орны эдийн засаг болон даатгалын салбарын хөгжилд өндөр хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Бидний тавьсан зорилгыг дэмжиж,

үнэтэй туршлагаасаа харамгүй хуваалцдаг хамтран ажиллагч байгууллагууд, аймаг, сумдын холбогдох ажилтнууд, даатгалын төлөөлөгчид болон эрсдэлээс өөрсдийн бизнесээ хамгаалж, даатгуулж буй баялаг бүтээгч харилцагчдадаа ямагт талархаж байдгаа дахин илэрхийлье.

Бизнесийн цар хүрээ тэлж, томрохын хэрээр харилцагчид, хувьцаа эзэмшигч, ажиллагсад, цаашлаад нийгэм, улс орныхоо өмнө хүлээх бидний үүрэг улам бүр өндөрсөж байгааг гүнээ ухамсарлаж даатгалын салбарын хөгжлийг шинэ шатанд аваачих, даатгуулагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн, олон улсын стандартыг хангасан давхар даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэн, амжилттай хэрэгжүүлэхийн тулд манай хамт олон хичээнгүйлэн ажиллах болно.

Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ЭНХТАЙВАН

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндэсний давхар даатгал ХК нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нэртэйгээр байгуулагдсан ба байгалийн болзошгүй болон гэнэтийн

эрсдэлээс малчид, тариаланчдыг хамгаалах зорилгоор олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээг дотоодын даатгалын компаниудаар дамжуулан үзүүлж ирсэн.

Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын

зардлыг багасгах зорилгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн нэрийг Үндэсний давхар даатгал ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн.

АЛСЫН ХАРАА

Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжинэ.



ҮНЭТ ЗҮЙЛС


МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ

Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин.



МАНЛАЙЛАЛ

Цаашдын зорилго зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэх нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.



ХАМТЫН ЗҮТГЭЛ

Бусадтай хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.



ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ

Монгол Улсын хууль журмыг чандлан мөрдөж, компанийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

ИЛ ТОД ХАРИЛЦАА ХОЛБОО

Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.



КОМПАНИЙН БҮТЭЦ

Үндэсний давхар даатгал ХК нь Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Комплаенс, нөхөн төлбөрийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар, Захиргаа, удирдлагын газар гэсэн 5 газар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

С.Наранцогт

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга

Ц.Болорчулуун

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

А.Дэмбэрэл

Үндэсний статистикийн хорооны Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга

П.Эрдэнэбаатар

Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн дарга

Н.Дэлгэрбат

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн мэргэжилтэн

Д.Насанжаргал

Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны удирдах зөвлөлийн гишүүн

Б.Шаравсамбуу

Хараат бус гишүүн

Ц.Түмэнхишиг

Хараат бус гишүүн

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант онд тус компанийн хөрөнгө өмнөх оноос **12 хувь** буюу **5.22 тэрбум** төгрөгөөр өсөж, нийт **48.61 тэрбум** төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын **15 хувийг** эзэлж байна. Мөн компанийн нөөц сан өмнөх оноос **600**

сая төгрөгөөр нэмэгдэж нийт **20.1 тэрбум** төгрөгт хүрлээ.


МИД-ын борлуулалт өмнөх оноос **33 хувиар** өсөж, **33,718** малчин өрхийг даатгаж **3 тэрбум 462 сая** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн бол нэрлэсэн эрсдэлт улаан буу-

дайн даатгал **215 хувиар**, газар тариалангийн тоног, төхөөрөмжийн даатгал **55 хувиар** өмнөх оноос тус тус өсөж нийт **181.9 сая** төгрөгийн хураамжийг төвлөрүүлэн ажиллалаа.


ЦЭВЭР АШИГ




НИЙТ ХӨРӨНГӨ



ДААТГАЛЫН ХУРААМЖ



НИЙТ НӨӨЦ САН



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Малын индексжүүлсэн даатгалд нийт **33,718** малчин хамрагдаж, **3 тэрбум 462 сая** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн **19.86 хувийг** эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос **9,571** өрхөөр, даатгалын хураамжийн орлого **1 тэрбум 133 сая** төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд **11** аж ахуйн нэгжийг МИГ даатгал ХХК, Ард даатгал ХК болон Бодь даатгал ХХК-уудтай хамтран даатган, давхар даатгалын хураамжид **115.6 сая** төгрөгийг төвлөрүүллээ. Эдгээр **11** аж ахуйн нэгжийн **5** аж ахуйн нэгжид нийт **590.6 сая** төгрөгийн нөхөн төлбөр олголоо.
- Газар тариалангийн хүнд машин, механизмын тоног төхөөрөмжийн даатгалд Ди Би Эм лизинг ХХК-тай хамтран ажиллаж, Миг даатгал


ХХК, Ард даатгал ХК болон Монгол даатгал ХХК-уудтай давхар даатгалын гэрээ байгуулан **120** аж ахуйн нэгж, иргэдийг хамруулав.

- Говь ХК-ийн үл хөдлөх хөрөнгө, бараа материал болон тоног төхөөрөмжийг даатгах нийт **246.2 тэрбум** төгрөгийн даатгалын үнэлгээ бүхий хам даатгалын гэрээнд дотоодын давхар даатгагчаар оролцов. Ингэснээр ойрын ирээдүйд давхар даатгалын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх ажлын эхлэл тавигдлаа.
- Бодь даатгал ХХК-тай хувь оролцооны давхар даатгалын гэрээ байгуулж, Сэлэнгэ аймгийн Мандал сумд байрлах Макс Агро ХХК-ийн **411** үхрийг даатгалд хамрууллаа.
- Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран 2018 оны 5 дугаар сард зохион байгуулсан

"Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал"-д МИД-ын хэрэгжилтийн талаар Азийн бага хурлын төлөөлөгчдөд танилцуулж, илтгэл тавилаа.

- Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспортын зээлийн даатгалын корпорац (ECGC Ltd) -тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.
- Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, даатгалын эрсдэлийг нэгдсэн журмаар олон улсад гаргаж, зардлыг бууруулах зорилгоор давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, Үндэсний давхар даатгал ХК болж өөрчлөгдлөө. Үндэсний хэмжээний давхар даатгалын тогтолцоог бий болгосноор дотоодын даатгалын зах зээлийн хөгжлийг идэвхжүүлэх болно.

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС



БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН

Малын индексжүүлсэн даатгал


Үндэсний давхар даатгал ХК-ийн дөрөв дэх жилийн борлуулалт, МИД-ын арван гурав дахь борлуулалтын улирал 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 21 аймгийн нийт **330** суманд эхэлснээс хойш 2018 оны 6 дугаар сарын сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд оролцогч даатгагчид болох Ард даатгал ХК, Бодь даатгал ХХК, Монгол даатгал ХХК, Монре даатгал

ХХК, МИГ даатгал ХХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК компаниуд оролцон нийт **33,718** малчинтай МИД-ын гэрээг байгуулж, **3.462 тэрбум** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн ба Төрийн болон Хаан банкнууд даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүллээ. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн


19.86 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос **9,571** өрхөөр, даатгалын хураамжийн орлого **1 тэрбум 133 сая** төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тайлант онд МИД-ын эрсдэл даах чадвар **12.3 тэрбум** төгрөг байв.




МИД-д даатгуулсан таван хошуу малын эзлэх хувь



Аймгийн малчин өрхөд МИД-д даатгуулсан малчин өрхийн эзлэх хувь



Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн **19.86** хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оноос **4.56** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/


Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал

Үндэсний давхар даатгал ХК нь 2018 онд Ард даатгал ХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК-уудтай нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын Хувь оролцооны давхар даатгалын гэрээ байгуулан ажиллалаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас улаан буудайн үр тариалах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдэд үрийн

буудайг даатгалд хамруулах чиглэл өгсний дагуу 9 аж ахуйн нэгж 1505.3 га талбайн үрийн буудайг, сайн дурын үндсэн дээр 2 аж ахуйн нэгж 1003 га талбайн таваарын буудайг тус тус даатгуулж, нийт 11 аж ахуйн нэгж 2508.3 га талбайн үрийн болон таваарын буудайн даатгалын гэрээг давхар даатгасан. Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын

бүтээгдэхүүний хариуцлага болон хураамжийн 15 хувийг дээрх 3 даатгалын компани, 10 хувийг Үндэсний давхар даатгал ХК, 75 хувийг СКОР (SCOR) олон улсын давхар даатгалын компани тус тус гэрээний дагуу хариуцаж даатгасан.

Даатгуулсан талбай (га)	Даатгалын хураамж	Даатгалын үнэлгээ
2508.3	136,079,091 ₮	1,077,856,601 ₮

**ДААТГУУЛСАН
ТАЛБАЙ:**

2016 он
250 га

2017 он
817 га

2018 он
2508.3 га

Газар тариалангийн хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас газар тариалангийн техникүүдэд шинэчлэл хийж буй ажлын хүрээнд Ди Би Эм лизинг ХХК-аас “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-аар дамжуулан түрээсэлж буй техникүүдийг Ард даатгал ХК, Монгол

даатгал ХХК, МИГ даатгал ХХК-уудтай хамтран давхар даатгах ажиллагааг зохион байгуулан ажиллав.

2017 онд 64 аж ахуй нэгж, иргэн даатгуулан 9.35 сая төгрөгийн давхар даатгалын хураамж төвлөрүүлсэн бол 2018 онд 105 аж ахуйн нэгжийн

15 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий тоног, төхөөрөмжийг даатган 23.8 сая төгрөгийн давхар даатгалын хураамж төвлөрүүлээ.



Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал

Эрчимжүүлсэн мал аж ахуйн давхар даатгал хийх ажлын хүрээнд Бодь даатгал ХХК-тай хувь оролцооны давхар даатгалын гэрээ байгуулж,

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх багт байрлах Макс Агро ХХК-ийн **169 үнээ, 114 бяруу, 128 тугал**, нийт **411 үхрийг** даатгалд хамруулан

нийт хураамжийн **50 хувь** болох **31.4 сая** төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлээ.

НӨХӨН ТӨЛБӨР

Малын индексжүүлсэн даатгал


2017 онд малаа даатгуулсан 24,148 малчин өрхөөс Улаанбаатар хотын Налайх дүүрэг, 19 аймгийн 130 сумын 8513 малчин өрхөд 1,091,975,096.95 төгрөгийн нөхөн төлбөрийг олгоод байна. Булган аймгийн Хишиг-Өндөр суманд үхрийн хорогдол 36.57 хувь,

Завхан аймгийн Завханмандал суманд ямааны хорогдол 33.47 хувь гарч тус аймгуудын хоёрдугаар босго үзүүлэлтээс давсан тул нөхөн төлбөрийн тооцооллын дагуу 5,400,551.53 төгрөгийг Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас,

1,086,574,545.42 төгрөгийг Хамтын эрсдэлийн сангаас тус тус олголоо.

2006 оноос хойш давхардсан тоогоор 29,362 малчин өрхөд 4.8 тэрбум төгрөгийн МИД-н нөхөн төлбөрийг олгоод байна.

МИД-н нөхөн төлбөр /сая төгрөгөөр/



Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал

Тайлант онд даатгалын гэрээний хэрэгжилтийн явцад нийт 36 удаагийн эрсдэлийн дуудлага ирүүлсэн ба үүнээс нийт 15 тохиолдолд нөхөн төлбөр болох 23.4 сая төгрөгийг олгоод байна.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал

Тайлант онд даатгуулсан талбайнуудад их хэмжээний цас орж тариалсан буудай дарагдсан, хүчтэй мөндөр орж буудайн болцын үед иш нь хугарч шим тэжээлийн дутагдалд орсон зэрэг эрсдэлүүдээс хохирол учирч 5 аж ахуйн нэгжид 590.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олголоо.

Нөхөн төлбөрийн санхүүжилт

Компани	Хариуцлагын хувь	Хураамжийн дүн	Нөхөн төлбөрийн дүн
Даатгагчид	15	20,411,863.68 ₮	88,592,888.86 ₮
Үндэсний давхар даатгал ХК	10	13,607,909.12 ₮	59,061,925.90 ₮
СКОР ОУДД-ын компани	75	102,059,318.39 ₮	442,964,444.28 ₮
Нийт	100	136,079,091.19 ₮	590,619,259.04 ₮



ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Экспортын зээлийн даатгал

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциатай хамтран уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд “экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх” нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэгч байгууллагаар Үндэсний давхар даатгал ХК ажиллаж байна.

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт сүүлийн жилүүдэд өсч 2017 онд 10537.9 сая ам.долларт хүрсэн ба өнгөрсөн оны мөн

үеийнхээс 27.4 хувиар буюу 2263.4 сая ам.доллараар өссөн. Экспорт 6200.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 27.4 хувиар өсчээ. Үүнээс нийт экспортын 80 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Монгол Улсын экспорт уул уурхайн салбараас хэт хамааралтай бөгөөд нийт экспортын 85 хувь нь Хятад улс руу гардаг байна.

Уул уурхайн бус салбарын экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэхэд Монгол Улсад дараах үндсэн хоёр бэрхшээл тулгарч байгаа ба экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлснээр эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Үүнд:

- Монгол Улсын экспортлогчид бэлэн мөнгөөр эсвэл аккредитиваар худалдаа хийдэг. Шинэ зах зээлд нэвтрэх, өрсөлдөхийн тулд гадаадын худалдан авагчдад нээлттэй данс мөн зээлийн нөхцөлөөр бараа, үйлчилгээгээ санал болгох шаардлагатай байна.
- Мөн экспортлогчдод тээвэрлэлтийн өмнөх санхүүжилт хэрэгтэй байдаг (ноос, ноолуур болон мах махан бүтээгдэхүүн зэрэг улирлын чанартай бүтээгдэхүүн экспортлогчид бүтээгдэхүүн боловсруулалт, хадгалалтын асуудалтай үргэлж нүүр тулдаг).



Даатгалын бүтээгдэхүүн

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДААТГАЛ

Экспортлогч эргэлтийн хөрөнгийн даатгалын гэрээг барьцаалан банкнаас эргэлтийн хөрөнгийн зээл авах бөгөөд экспортлогч буюу зээлдэгч зээлээ төлөхгүй байх эрсдэлээс банк болон бусад санхүүгийн байгууллагыг хамгаална.

Ямар хэрэгтэй вэ?

- Эргэлтийн хөрөнгөдөө санаа зоволгүйгээр хилийн чанадаас бараа бүтээгдэхүүний захиалга авах
- Банкнаас санхүүжилт олгохдоо барьцаа хөрөнгө шаардахад даатгалын гэрээгээ барьцаа болгон, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ санхүүжүүлж, өргөжүүлэх
- Бараа захиалагч нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ найдвартай хүлээн авна гэсэн итгэлтэй болох давуу талтай.

Аж ахуй нэгж ямар эрсдэлээс хамгаалагдах вэ?

Экспортлогч санхүүгийн байгууллагаас авсан зээл Экспортлогч төлбөрийн чадваргүй болох

БОГИНО ХУГАЦААТ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

Экспортын гэрээний дагуу төлбөр хийгдэхгүй байх эсвэл гэрээний гүйцэтгэл, цуцлалт зэргээс үүдэн гүйцэтгэлийн зөрдлыг нөхөж чадахгүй байх эрсдэлээс экспортлогчийг хамгаална.

Ямар хэрэгтэй вэ?

- Бараа бүтээгдэхүүн шилжүүлсний дараа худалдан авагч нь дампуурах, төлбөрийн чадваргүй болох, төлбөрөө хугацаанд нь төлөхгүй байх эрсдэлээс хамгаалагдаж, орлогоо тогтвортой хадгалах
- Худалдан авагчийнхаа санхүүгийн найдвартай байдлыг үнэлүүлж, аюултай зах зээлд, худалдан авагчид бараагаа нийлүүлээд орлогогүй болох вий гэсэн айдастгүйгээр нээлттэй дансны нөхцөлтэйгөөр худалдаа наймаа хийж, худалдан авагчийнхаа тоог нэмэгдүүлэн, зах зээлээ тэлэх давуу талтай.

Аж ахуй нэгж ямар эрсдэлээс хамгаалагдах вэ?

Арилжааны:

- Худалдан авагч төлбөрийн чадваргүй болох, дампуурах, төлбөрийн удаашрал

Улс төрийн:

- Худалдан авагчийн ЗГ-ын шийдвэрийн дагуу
- Төлбөрийг зогсоох,
- Валютын үл хөрвөх байдал,
- Худалдан авагч компанийг улсын мэдэлд авах,
- Хөрөнгийг албадан хураах,
- Экспорт, импортын лицензийг цуцлах, сунгахгүй байх, хүчингүй болгох,
- Дайн, иргэний дайн, бослого, үймээн самууны улмаас төлбөр төлөлт хойшлох



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Монголын Улаан Загалмай Нийгэмлэг, Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжиж 11 дүгээр сарын 24-нөөс 25-ны өдөр Говь-Алтай, Увс, Төв аймагт болсон хүчтэй шуурганд өртөн зудын гамшигт нэрвэгдэх эрсдэл бүхий малчин өрхүүдэд туслах ажлыг зохион байгуулав. Уг тусламжаар нийт 62 сая төгрөгийн 30 иж бүрэн монгол гэрийг Говь-Алтай, Увс, Төв аймгуудын гамшигт өртсөн өрхүүдэд олгов.



Манай компанийн ажилтнууд 2018 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Улсын хэмжээнд дутагдалтай байгаа цус цусан бүтээгдэхүүний нөөцөд хувь нэмэр оруулах зорилгоор цус сэлбэлт судлалын үндэсний төвд хандан, цусаа хандивлаж сайн үйлсийн аянд нэгдлээ. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн цус цуглуулах явуулын баг ирж ажилтнуудын цусыг цуглуулсан юм. Ташрамд дурдахад цусны донороос 350-400 грамм цусыг нэг удаа авдаг бөгөөд уг цус нь 3 насанд хүрсэн хүнд буюу 5 хүүхдэд амьдрал бэлэглэдэг байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласан байдаг. Тус өдөрт зориулан мод, бут, сөөг тарих газруудыг сонгож бэлтгэн албан байгууллага, хувь хүмүүст хуваарилан өгдөг юм. Үүний дагуу Үндэсний давхар даатгал ХК –ийн ажилтнууд уг олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцлоо. Манай компанийн хувьд тус өдрийг тохиолдуулан улиас модыг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ажилтнуудын зааварчилгааны дагуу тарьж суулгалаа. Цаашид жил болгон очиж суулгасан модоо арчлан хамгаалж байх юм.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Малын индексжүүлсэн даатгалын эрсдэлийн дунд түвшинд олон улсын давхар даатгалын SCOR / SCOR/ компанитай, эрсдэлийн дээд түвшинд Ханновер ре /Hannover Re/ компанитай алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.
- Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд даатгасан эрсдэлийн 25 хувийг дотооддоо даатгаж, үлдсэн 75 хувийг SCOR /SCOR/ компанид даатгуулж хувь оролцооны гэрээ байгуулан ажиллалаа.
- ОХУ-ын Рашин ре /Russian Re/ давхар даатгалын компанитай байгуулсан санамж бичгийн хүрээнд давхар даатгалын зах зээлийн туршлага судаллаа.
- Швейцарийн Цельсиус Про /Celsius Pro/ компанитай хамтран гамшгийн даатгалын нэг төрөл болох газар хөдлөлтийн параметрийн даатгалын бүтээг-дэхүүнийг боловсруулах, загварчлах ажлыг хийж байна.
- Экспортын даатгалын бүтээг-дэхүүнийг нэвтрүүлэх чиглэлээр гадаадын экспортын зээлийн даатгалын агентлагуудтай болон Дэлхийн банкны олон улсын мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллалаа. Тухайлбал БНХАУ-ын Синошүр /Sinosure/, ОХУ-ын ЭКСАР /EXIAR/, Интерфакс, БНКаЗУ-ын КазахЭкспорт /KAZAKHEXPORT/, БНЭУ-ын ECGC гэх мэт.
- “Монгол-Оросын Санаачилга 2018” олон улсын бага хуралд оролцож, ОХУ-ын Экспортын даатгалын агентлагийн төлөөлөлтэй хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулсан.
- Беларусь улсын экспортын зээлийн даатгалын “Белэксимгарант” компанитай экспортын даатгалын салбарт хамтран ажиллахаар тохиролцов.
- Франц улсын Парис хотноо зохион байгуулагдсан экспортын даатгагчдын Бернийн холбооны уулзалтанд 2 дахь удаагаа оролцов.
- Бүгд Найрамдах Энэтхэг улсын Экспортын зээлийн даатгалын корпорац (ECGC Ltd) -тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.
- Их Британи Улсын Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болох Английн Сансарын агентлагаас санхүүжилттэй Сибэлиус /SI-BELIUs/ төсөл хөтөлбөрийн хүрээнд хиймэл дагуулаас авсан цаг агаарын мэдээг малын даатгалд ашиглах, цаг агаарт суурилсан малын даатгалыг боловсруулж, малчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалан амьжиргааг сайжруулахад хамтран ажиллаж байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ ТАНАА:

ДҮГНЭЛТ

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Хураангуй санхүүгийн байдлын тайлан болон тухайн жилийн Хураангуй ашиг алдагдал болон дэлгэрэнгүй орлогын тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу Компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Компанийн СТОУС-ын дагуу бэлтгэсэн аудитлагдсан санхүүгийн тайланг орлохгүй.

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН БИДНИЙ ДҮГНЭЛТ

Бид 2019 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн аудиторын дүгнэлтээрээ тухайн аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн.

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГУУДАЙ ХОЛБООТОЙГООР УДИРДЛАГЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

“Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу санхүүгийн хураангуй тайланг бэлтгэх нь Компанийн удирдлагын хариуцлага юм.

АУДИТОРЫН ХАРИУЦЛАГА

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”) 810 буюу “Санхүүгийн Хураангуй Тайлангийн Талаар Дүгнэлт Өгөх Гэрээт Ажил”-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:
Захирал:

Батбаярын Мөнхжин
Адриан Чу Партнер

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2018 Мян.төг	2017 Мян.төг
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	517,197	363,229
Биет бус хөрөнгө	375,474	423,300
Нийт эргэлтийн бус хөрөнгө	892,671	786,529
Эргэлтийн хөрөнгө		
Хадгаламж, үнэт цаас	46,750,931	41,635,403
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	242,017	205,193
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлага	45,498	315,597
Даатгалын хураамжийн авлага	14,830	20,721
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	664,259	431,186
Нийт эргэлтийн хөрөнгө	47,717,535	42,608,100
НИЙТ ХӨРӨНГӨ	48,610,206	43,394,629

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Эздийн өмч		
Эзэмшигчдийн өмч	15,000,000	15,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	489,264	489,264
Алдагдлаас хамгаалах нөөц сан	15,000,000	15,000,000
Хуримтлагдсан ашиг	11,671,887	7,669,695
Нийт эздийн өмч	42,161,151	38,158,959

Өр төлбөр		
Хамтын эрсдлийн сан	1,648,163	1,165,807
Эрсдлээс хамгаалах нөөц сан	3,564,217	3,270,696
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	694,482	460,217
ААНОАТатварын өглөг	151,894	131,002
Урьдчилж олсон орлого болон бусад өглөг	72,196	105,950
Давхар даатгагчид өгөх өглөг	318,103	101,998
Нийт өр төлбөр	6,449,055	5,235,670
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	48,610,206	43,394,629

Тодруулга: "Тайлан бэлтгэх үндэслэл. Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК (цаашид "Компани" гэх)-ийн энэхүү хураангуй тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ямар нэгэн өөрчлөлтгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно."

ОРЛОГЫН ТАЙЛАН

	2018 Мян.төг	2017 Мян.төг
Даатгалын нийт хураамжийн орлого	1,738,278	1,303,138
Даатгалын хураамжийн буцаалт	(17,530)	-
Давхар даатгалын хураамж	(825,298)	(577,527)
Даатгалын цэвэр хураамжийн орлого	895,450	725,611
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн өөрчлөлт	(234,265)	548,485
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	36,824	(222,896)
Нийт орлогод тооцсон хураамж	698,009	1,051,200
Нийт нөхөн төлбөрийн зардал	(521,939)	(204,838)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	442,964	168,939
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(293,521)	(206,219)
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(372,496)	(242,118)
Хөрөнгө оруулалтын орлого	6,183,779	5,814,162
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	314,305	137,709
Үйл ажиллагаа, ерөнхий удирдлагын зардал	(1,987,955)	(1,908,232)
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(172,879)	(129,027)
Татвар төлөхийн өмнөх ашиг	4,662,763	4,723,694
Орлогын татварын зардал	(605,807)	(404,011)
Татварын дараах ашиг	4,056,956	4,319,683

Тодруулга: "Тайлан бэлтгэх үндэслэл. Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК (цаашид "Компани" гэх)-ийн энэхүү хураангуй тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ямар нэгэн өөрчлөлтгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно."

ГАДААД ТҮНШҮҮД:

SCOR

Swiss Re

SIBELIUS

berneunion

hannover re®

ECGC

(A Government of India Enterprise)

You focus on exports. We cover the risks.



RUSSIAN
REINSURANCE
COMPANY

ДОТООД ТҮНШҮҮД:



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



МОНГОЛ ДААТГАЛ

МАНДАН
ДААТГАЛ



МОНРЕ
ДААТГАЛ

БОДЬ ДААТГАЛ
САЙН САНХҮЙГ ИТГЭЛЭЭР ХАМГААЛНА

MIG

ТЭНГЭР
ДААТГАЛ

ПРАКТИКАЛ
ДААТГАЛ

НОМИН
ДААТГАЛ

ХААН БАНК

ТӨРИЙН БАНК

ARD

ХААН
ДААТГАЛ

Улаанбаатар хот-14251, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, 5-р хороолол, 10Б байр, Бизнес
тауэр, 20 давхар

(+976) 7577-0002

info@mongolianre.com

www.mongolianre.com